



БАТЛАВ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ-2023 ОН

2023.03

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

Зорилго: Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас ирүүлсэн Төсвийн өрөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилт, Эрүүл мэндийн газрын 2022 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилтийг хариуцах албан тушаалтан	Хамтран ажиллах
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох болон тайлاغнах чиглэлээр:					
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхой төлөвлөх	Төлөвлөгөө	1-р улиралд	Үдирдлага төлөвлөлтийн хэлтэс	Хэлтсүүд, НЭМТөв,
2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг тайлангийн хамт албан бичгээр ЭМЯ-нд хугацаанд нь хургуулэх /цахимаар/	Хяналт шинжилгээний үнэлгээний дүн, УЗХ-ын шийдвэр	Хагас бүтэн жилээр	ХШУДАХ ахлах мэргэжилтэн	Хэлтсүүд, НЭМТөв, Удирдлагын зөвлөл
Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:					
3	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн, үнэн зөв, бодитой, тодорхой тайлاغнах, тайландаа холбогдох мэдээлэл, судалгааг хавсаргаж хүргүүлэх	Тайлан	12-р сард	ЭМАНАСХ мэргэжилтэн ХНТХМЗХ мэргэжилтэн	Үдирдлага төлөвлөлтийн хэлтэс
4	Зохион байгуулах сургалтын зорилтот түвшинг сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тодорхойлж, хэрэгжилтийг тайлагнах, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг бодитой тайлагнах	Сургалтын төлөвлөгөө, тайлан	12-р сард	ЭМАНАСХ мэргэжилтэн ХНТХМЗХ мэргэжилтэн	Үдирдлага төлөвлөлтийн хэлтэс
5	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувийг гаргаж өмнөх онтой харьцуулан тайлагнах	Шилжилт хөдөлгөөний хувь	12-р сард	ХНТХМЗХ мэргэжилтэн	БОЭТ, СЭМТ

6	Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцох	Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүн	10-р сард	ЭМАНАСХ мэргэжилтэн	БОЭТ, СЭМТ
7	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын мөрөөр арга хэмжээ авч ажиллан албан хаагчдыг мэдээллээр хангах	Тайлан	Жилийн турш	ЭМАНАСХ мэргэжилтэн	БОЭТ, СЭМТ
<b>Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр:</b>					
8	Монгол Улсын 2021 оны "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж, сурталчилж ажиллах	Хуулийн хэрэгжилтийн хувь	Жилийн турш	Мэдээлэл технологийн мэргэжилтэн	Хэлтсүүд, НЭМТөв,
9	Төрийн байгууллагын цахим хуудаст тавигдах шаардлага MNS6285:2017" стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулах	Стандартын хэрэгжилт	Жилийн турш	Мэдээлэл технологийн мэргэжилтэн	Хэлтсүүд, НЭМТөв,
10	Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилт	Жилийн турш	БТХЭЭТЗХ мэргэжилтэн	Хэлтсүүд, НЭМТөв,
11	Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг тайланд шалгур үзүүлэлт бүрийн дагуу товч, тодорхой, холбогдох нотлох баримт, гарсан шийдвэр, бүртгэл, судалгааг хавсаргаж тайлагнах	Тайлан	Хагас, бүтэн жилээр	Хэлтэс, НЭМТ-ийн ахлах мэргэжилтнүүд	Хэлтсүүд, НЭМТөв,
12	Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн зарчмыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн байршуулах	Хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн байршуулсан байдал	Тухай бүр	ССБМНБ ажилтан	Удирдлага төлөвлөлтийн хэлтэс
13	Ил тод байдалд тавих дотоод хяналтыг сайжруулах	Дотоод хяналтын дүн, зөвлөмж	Хагас, бүтэн жилээр	Хэлтэс, НЭМТ-ийн ахлах мэргэжилтнүүд	Дотоод хяналтын баг
<b>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр:</b>					
14	Эмнэлгийн орны төлөвлөлтөд орон нутгийн онцлог, хүн амын нягтаршил, алслагдсан байдал, хүний нөөцийн чадамж, өвчний чиг хандлагыг үндэслэн санал боловсруулж ЭМЯ-нд хүргүүлэх	Хүргүүлсэн санал	2-р улирал	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭТҮХэлтэс
15	ЭМТҮЧБА-аас эмнэлэгт бүртгэгдсэн өвчлөл, нас барагт, давтан хагалгаа, хагалгааны хүндрэл, түүнд нөлөөлсөн шалтгааныг судалж, удирдлага, мэргэжилтнүүдийг цаг тухай бүр нь мэдээллээр хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж ажиллах	Судалгааны дүн, тайлан	Тухай бүр	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭТҮХэлтэс ХШҮМХэлтэс

16	Эмнэлгийн тайлан, мэдээ гаргаж буй эмч мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд удирдлага, дотоод хяналтын нэгжээс тогтмол хяналт тавьж ажиллах	Хяналтын дүн, зөвлөмж	Тухай бүр	Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн	ЭМБ-ууд Дотоод хяналтын баг
17	Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралтаас зайлшгүй эмгэг судлалын шинжилгээнд хамрагддаг тохиолдол /11-уудыг бүрэн хамруулах, эмчилгээ үйлчилгээний дутагдал, хоног болоогүй нас баралт, давтан мэс засал, мэс заслын дараах хүндрэл зэрэг үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэхгүй байх тал дээр эмнэлгийн удирдлагууд онцгой анхаарч тодорхой ажил зохион байгуулах	Эмнэлэгт бүртгэгдсэн нас баралтаас зайлшгүй эмгэг судлалын шинжилгээнд хамрагдсан хувь Хоног болоогүй нас баралт, давтан мэс засал, мэс заслын дараах хүндрэлийн хувь	Жилийн турш	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭТҮХэлтэс ҮТХэлтэс ХШҮМХэлтэс

**Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:**

18	Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчиний илрүүлэг шинжилгээ болон улсын хэмжээнд зохион байгуулж байгаа эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 18-аас дээш насны хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулж, өвчлөл илэрсэн тохиолдлыг эмнэлгийн хяналтад авч хяналт тавьж ажиллах	Халдварт бус өвчиний илрүүлгийн хувь эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 18-аас дээш насны иргэдийн хамрагдсан хувь	Жилийн турш	ЭМБСС, ОНХ ахлах мэргэжилтэн	СӨЭМТ-үүд ЭМДТөв
----	--	--	-------------	------------------------------	---------------------

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чиглэлээр:**

19	Жирэмсний эрт үеийн хяналт ба тогтмол хяналтын үйл ажиллагааг чанаржуулах, аливаа эмгэгийг эрт үед нь илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	Жилийн турш	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭТҮХэлтэс СӨЭМТ-үүд
20	Өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, жирэмснээс хамгаалах арга хэрэгслийг таниулах, сурталчлах эрүүл мэндийн боловсрол олгох	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан өсвөр насны хүүхдийн тоо	Жилийн турш	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	БСУГ ХГБЗХГ

**Хэрэглэгчийн үнэлгээний талаар:**

21	Амбулаторийн эмчийн үзлэгийн цагийн болон орны хүлээгдлийг багасгах, эмнэлгийн эм тария, ороох боох хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн мэргэжилтний үйлчлүүлэгчид эмчилгээний талаар тайлбарлах, үйлчлүүлэгчийг анхааралтайгаар сонсох ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах	Тайлан	Жилийн турш	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭМБ-ууд
22	Эрүүл мэндийн байгууллагууд үйлчилгээ авсан иргэдийг хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах соёлыг түгээн дэлгэрүүлэхэд санаачилга гарган ажиллах	Тайлан	Жилийн турш	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭМБ-ууд

23	Жилийн турш авч байгаа хэрэглэгчийн үнэлгээндээ тогтмол дүн шинжилгээ хийж сэтгэл ханамж хангалтгүй байгаа чиглэлээр эрүүл мэндийн байгууллагууд анхаарч, тусlamж, үйлчилгээнийхээ чанарыг тогтмол сайжруулж ажиллах	Хийгдсэн дүн шинжилгээ, авсан арга хэмжээний тайлан	Жилийн турш	ЭТЧЭМИХ ахлах мэргэжилтэн	ЭМБ-үүд
<i>Бусад үйл ажиллагааны чиглэлээр:</i>					
24	Орон нутгийн төсвөөс эрүүл мэндийн чиглэлээр зарцуулсан санхүүжилтийн менген дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тодорхой, тоо баримттай тайлагнах	Тайлан	Жилийн турш	ЭМЭЗТТЗХ мэргэжилтэн	Хэлтсүүд, НЭМТ
25	Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан, эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг эрчимжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах	Тайлан	Жилийн турш	ССБМНБ ажилтан	УТХэлтэс
26	Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр цахим хэлбэрээр цаг хугацаанд нь ирүүлж хэвшүүлэх	Гэрээний хэрэгжилтийн хувь	12-р сард	ХШУДАХ ахлах мэргэжилтэн	Хэлтсүүд, НЭМТөв,

ТӨЛӨВЛӨГӨӨ НЭГТГЭСЭН: ХШУДАХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Г.ЭНХЖАРГАЛ